



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/147

Мандалговь

Чанарын удирдлагын хороо
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "г" дэх, Засгийн газрын 2008 оны 265 дугаар "Төлөвлөгөө батлах тухай" тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газарт "Чанарын удирдлагын тогтолцоо" ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх "Чанарын удирдлагын хороо"-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---------------------------|---|
| Удирдлагын хорооны дарга: | Ц.Эрдэнэсүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга) |
| Гишүүд: | М.Цогзолмаа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга) Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга) А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга) Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга) А.Ганбат (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга) Г.Самданцоодол(Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын хэлтсийн дарга) |
| Нарийн бичиг: | Г.Жавзмаа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн) |

Хоёр. ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог Засаг даргын Тамгын газарт үр дүнтэй, төлөвлөгөөний дагуу хугацаанд нь хэрэгжүүлж, тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190400